



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2020/24/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2020 он

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг

Утас:261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:Ц.Хосжаргал

Утас:261885 Цахим хаяг:khosjargalts@audit.gov.mn

Ахлах аудитор:Р.Цолмон

Утас:260512 Цахим хаяг:tsolmonr@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1 Мөнгөн хөрөнгө	7
2.8.2 Авлага.....	8
2.8.3 Урьдчилгаа	9
2.8.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	10
2.8.5 Бараа материал	10
2.8.6 Үндсэн хөрөнгө.....	11
2.8.7 Өр төлбөр.....	12
2.8.8 Засгийн газрын хувь оролцоо.....	13
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	13
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	16
2.11. Шилэн дансны мэдээлэл	16
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	16
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	16
3. Менежментийн захидал.....	18
3.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал	18
3.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал.....	17
3.3 Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал.....	18
3.4 Дотоод аудит, дотоод хяналтын талаар.....	18
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	21
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	23
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	24
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	26
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	27
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	30
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
СС	Сангийн сайд
ЗТХЯ	Зам, тээврийн хөгжлийн яам
ТУЗ	Төлөөлөн Удирдах зөвлөл
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨХ	Төрийн өмчийн хороо
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ОУНБ	Олон улсын нисэх буудал
НБУГ	Нисэх буудлуудын удирдах газар
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАМ,ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД
Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2020.04.24 № 1433
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Аудитын гол асуудал

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 27,585.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээр тогтоосон материаллаг байдлын түвшнээс 14,082.5 сая төгрөгөөр их байгаа нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, тохиолдсон байх, оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Д.ЗАНДАНБАТ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн харилцагч байгууллагуудтай тооцоо нийлж, олон жил болсон авлагуудыг барагдуулах, хяналт тавьж ажиллах, харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-т заасны дагуу Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 4 дүгээр сарын 10-аас 2020 оны 4 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон гүйцэтгэв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 03/1480 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь эдийн засгийн өсөлтийг хангах, зам, тээвэр, логистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээний нөхцөлийг бий болгох явдал юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Салбарын хөгжлийг дэмжсэн хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төслийг боловсруулах, бодлогын удирдамжаар хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, оновчтой хуваарилах, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, төсөв төлөвлөх, хэрэгжүүлэх, салбарын стандарт, норматив, техник, технологийг хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Авто замын салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Авто тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- Төмөр зам, далай ашиглалт болон усан замын тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;
- Иргэний нисэхийн хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, биелэлтийг хангуулах;
- Зам тээврийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үр дүнд нь үнэлгээ, дотоод аудит хийх, захиргааны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх гэх мэт.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалаар Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан;
- Тээврийн хэрэгслийн гэрчилгээний орлогыг Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн тайланд тусгасан;
- Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журамд өөрчлөлт хийгджээ.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Зам, тээврийн хөгжлийн яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Зам, тээврийн хөгжлийн яамны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

Зам, тээврийн хөгжлийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2019 онд харьяа орон нутаг дахь 4 газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 12 заалт бүхий 1 зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж, арга хэмжээ авч ажиллаагүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Зам, тээврийн хөгжлийн сайдын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 10 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 377,178.1 сая төгрөгийн 1 хувь буюу 3,771.8 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд аудитын залруулга хийснээр нийт борлуулалтын өртөг 538,703.9 сая төгрөг, үйл ажиллагааны зардал 790,481.5 сая, үйл ажиллагааны бус зардал 21,143.6 сая төгрөг нийт 1,350,329.0 сая төгрөгийн зардлын 1 хувь буюу 13,503.3 сая төгрөгөөр тогтоов.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 194,873.8 сая, эцсийн үлдэгдэл 389,200.0 сая төгрөг болж, 194,326.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	306.9	253.3	(53.6)
Банканд байгаа бэлэн мөнгө	152,393.0	354,794.8	202,401.8
Замд яваа мөнгөн хөрөнгө	3.3	4.1	0.8
Хадгаламж	42,170.6	34,147.8	(8,022.8)
Дүн	194,873.8	389,200.0	194,326.2

Үүнээс, байгууллагын төрлөөр

Төсөвт байгууллага	20,966.6	52,843.5	31,876.9
Төсөл/сан	527.5	32.1	(495.4)
ТӨҮГ болон ОНӨҮГ	173,379.7	336,324.4	162,944.7
Дүн	194,873.8	389,200.0	194,326.2

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Банканд байршиж буй 354,794.8 сая төгрөгөөс гадаад валютаарх үлдэгдэл 43,821.8 сая төгрөг байгаа нь төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын үлдэгдэл байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Чингис хаан олон улсын нисэх буудлын тээврийн хэрэгслийн нэвтрэх цэгийн бүртгэлийн хураамж болон рестораны үйлчилгээний орлогыг оны эцсийн өдөр шилжүүлснээс үүссэн 4.1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Хадгаламж дансны үлдэгдэл нь МИАТ ТӨХК-ийн 34,147.8 сая төгрөгийн хадгаламж байна.

Аудитын илрүүлэлт:

- Анхан шатны бүрдэлгүй, хүчин төгөлдөр бус баримтаар нийт 128.2 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн, зөрүүтэй тайлагнасан /Монголын төмөр зам ТӨХК 8.3 сая, АТҮТ 101.3 сая, Дорноговь АЗЗА 0.5 сая, Сэлэнгэ АЗЗА 12.6 сая, Налайх АЗЗА 5.5 сая төгрөг/
- Мөнгөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, биетээр оршин байхгүй, ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргасан, мөнгөн хөрөнгийн зарцуулалт тодорхой бус нийт 666.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн. /МИАТ ТӨХК 14.0 сая, ИНЕГ 38.4 сая, Чингис хаан ОУНБ 12.6 сая, Орхон АЗЗА 7.3 сая, АТҮТ 391.7 сая, Сэлэнгэ АЗЗА 26.5 сая, Сүхбаатар АЗЗА 152.6 сая, Төв АЗЗА 4.7 сая, Баянхонгор аймгийн Гурвансайхан нисэх буудал 18.5 сая төгрөг/
- Кассын үлдэгдлийг тухай бүр харилцах дансанд тушаагаагүй нийт 161.6 сая төгрөгийн зөрчил байна. /Чингис хаан ОУНБ-61.2 сая, АТҮТ 100.4 сая төгрөг/

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 114,915.7 сая, эцсийн үлдэгдэл 133,212.9 сая төгрөг болж, 18,297.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	95.2	94.6	(0.6)
Төлбөртэй үйлчилгээний авлага	41,992.9	43,823.2	1,830.3
Татаас, санхүүжилтийн авлага	714.0	1,510.7	796.7
Дансны авлага /ТӨҮГ/	35,467.2	32,637.8	(2,829.4)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	15,650.8	17,933.7	2,282.9
Бусад авлага	20,995.6	37,212.9	16,217.3
Дүн	114,915.7	133,212.9	18,297.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,549.4	7,296.5	(1,252.9)
Төсөл/ сан	714.0	1,510.7	796.7
ТӨҮГ болон ОНӨҮГ	105,652.3	124,405.7	18,753.4
Дүн	114,915.7	133,212.9	18,297.2

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд олон жил болсон 14,929.7 сая төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- ИНЕГ-ын агентлаг болон үйлдвэрлэлийн албаны 2008 онд үүссэн нийт 2,209.3 сая төгрөгийн авлага, 2001 онд үүссэн тооцоо нийлсэн актгүй, агаарын тээвэрлэгчдийн навигацийн үйлчилгээний орлогын 1,909.7 сая төгрөгийн авлага.

- Чингис хаан ОУНБ-ын дансны авлагын 12,782.4 сая төгрөгийн үлдэгдлийн 84.3 хувь буюу 10,810.7 сая төгрөгийн дотоодын авиа компаниудаас авах авлагыг барагдуулаагүй байна. Үүнд 2014 оноос өмнө үүссэн 8,576.2 сая, 2015 онд үүссэн 407.3 сая, 2016 онд үүссэн 42.7 сая нийт 9,026.2 сая төгрөгийн авлага нь МИАТ компани, АэроМонголиа ХХК, Хүннү Эйр ХХК-аас тус тус авах авлага байна.

Аудитын илрүүлэлт:

- Нийт 1,056.6 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, 333.5 сая төгрөгийн авлагыг нэгжийн тайланд устгах бичилт хийсэн. /НБУГ 753.7 сая, Чингис хаан ОУНБ 333.5 сая, ЗТХТ 15.1 сая, Сэлэнгэ АЗЗА 5.1 сая, Орхон АЗЗА 182.1 сая, Баянчандмань АЗЗА 7.7 сая, Булган АЗЗА 92.9 сая төгрөг/
- Олон жил болсон 13,391.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй /МИАТ ТӨХК 173.7 сая төгрөг, АТҮТ 26.0 сая, ИНЕГ 4,119.0 сая, Чингис хаан ОУНБ 9,026.2 сая, Сэргээн засах амралт 11.1 сая, Төв АЗЗА 35.6 сая төгрөг/
- Данс бүртгэлд 49.3 сая төгрөгийн авлагыг бүртгээгүй /МИАТ ТӨХК 17.0 сая төгрөг, НБУГ 27.4 сая, Далайн захиргаа 0.6 сая, Эрэндэнсант Азза 4.3 сая төгрөг/.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 58,508.7 сая, эцсийн үлдэгдэл 228,841.2 сая төгрөг болж, 170,332.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	27,390.7	228,217.8	200,827.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.2	9.4	9.2
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	31,117.4	562.1	(30,555.3)
Томилолтын урьдчилгаа	0.4	0.0	(0.4)
Дүн	58,508.7	228,789.3	170,280.6
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	8,297.7	0.0	(8,297.7)
ТӨҮГ болон ОНӨҮГ	50,211.0	228,789.3	178,578.3
Дүн	58,508.7	228,789.3	170,280.6

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2018-2019 онд үүссэн 227,683.1 сая төгрөгийн бараа ажил, үйлчилгээний урьдчилгаа төлбөрүүд байна. Тухайлбал:

- Монголын төмөр зам ТӨХК Тавантолгой Зүүнбаян чиглэлийн 415 км төмөр зам барих төслийн барилгын ажлын 211,770.2 сая төгрөгийн зардлыг хуримтлуулан бүртгэсэн;
- МИАТ ТӨХК 8,585.5 сая төгрөгийн Wells Fargo Bank Northwest, National Association банкнаас авсан зээлд байршуулсан урьдчилгаа, 3,432.8 сая төгрөгийн Агаарын хөлгийн сэлбэг тээвэрлэлт болон агаарын хөлгийн даатгал, нисэх бүрэлдэхүүний амь насны даатгалын урьдчилгаа, 1,321.0 сая төгрөгийн агаарын хөлгийн сэлбэг захиалгын урьдчилгаа, ажилтан албан хаагчидтай дараа тооцоогоор үүссэн 1,020.1 сая төгрөгийн урьдчилгаа;
- ИНЕГ 2018-2019 онд үүссэн даатгалын үйлчилгээний төлбөрийн 1,300.3 сая төгрөг, инженер техникийн ажилчдаар хийлгэж байгаа нислэгийн бүртгэлийн программ хангамжийн 253.2 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрүүд байна.

Аудитын илрүүлэлт:

- МИАТ ТӨХК нь тайлант онд ажилтан албан хаагчдын 112.2 сая төгрөгийн албан томилолтын дараа тайлангийн тооцоог хийж баталгаажуулаагүйгээс тайлант оны зардлаар бүртгээгүй;
- Баянчандмань АЗЗА тайлант хугацаанд ажилчдад 26.4 сая төгрөгийн хээрийн нэмэгдэл олгоходоо анхан шатны бүртгэлгүй, урьдчилгаа тооцоо үүсгэхгүй зардлаар бүртгэсэн, УБ Дарханы түр замын ажлын гүйцэтгэл 505.3 сая төгрөгийг санхүүжүүлэгч байгууллагатай хийсэн гэрээ хэлцэл тооцоо нийлсэн актгүй байна.

2.8.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 191.2 сая, эцсийн үлдэгдэл 35,535.4 сая төгрөг болж, 35,344.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Үнэт цаас	190.2	191.2	1.0
Урт хугацаат зээл	1.0	35,344.2	35,343.2
Дүн	191.2	35,535.4	35,344.2
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
ТӨҮГ болон ОНӨҮГ	191.2	35,535.4	35,344.2
Дүн	191.2	35,535.4	35,344.2

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл тайлант онд Засгийн газрын 175 дугаар тогтоолоор Монгол-Японы хамтарсан компанийн 49.0 хувийг эзэмших зориулалтаар 35,290.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр нэмэгдсэн байна.

2.8.5 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 502,322.5 сая, эцсийн үлдэгдэл 556,801.6 сая төгрөг болж, 54,479.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	28,445.0	36,799.5	8,354.5
Дуусаагүй үйлдвэрлэл	427,038.9	444,706.9	17,667.9
Бэлэн бүтээгдэхүүн	575.6	1,383.6	808.0
Бичиг хэргийн материал	32.7	51.8	19.1
Аж ахуйн материал	9,601.0	20,798.1	11,197.1
Сэлбэг хэрэгсэл	1,467.8	2,117.1	649.3
Түлш, шатах тослох материал	407.9	334.1	(73.7)
Барилгын засварын материал	28,368.4	28,368.4	0.0
Бусад хангамжийн материал	6,304.0	22,196.3	15,892.4
Мал амьтад	81.3	45.8	(35.5)
Дүн	502,322.5	556,801.6	54,479.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	83.7	114.7	31.0
Төсөл/ сан	44.8	37.0	(7.8)
ТӨҮГ болон ОНӨҮГ	502,194.0	556,649.9	54,455.9
Дүн	502,322.5	556,801.6	54,479.1

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст худалдан авсан иргэний нисэхийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангах зориулалтаар 10,090.7 сая төгрөгийн бараа материалыг нөөцөлсөн байна. /МИАТ ТӨХК 8,482.6 сая, ИНЕГ 1,608.1 сая төгрөг/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон ТӨБЗГ-ын тогтоол гараагүйгээс ашиглагч байгууллагад шилжүүлээгүй 45,687.4 сая төгрөгийн 20 хөрөнгө бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны журмыг зөрчиж нийт 578.4 сая төгрөгийн бараа худалдан авсан /Чингис хаан ОУНБ 382.7 сая, Багануур АЗЗА 16.4 сая, Хөвсгөл аймаг дахь Нисэх буудал 179.3 сая/;
- Бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй, тооллого хийж баталгаажуулаагүй, бараа материалын орлогод бүртгэлгүйгээр зардалд шууд тусгасан 166.9 сая төгрөгийн зөрчил /ИНЕГ 148.0 сая, АТҮТ 18.9 сая/;
- Их хэмжээний бараа материал худалдан авч 31.7 сая төгрөгийн үргүй зардал гаргасан. /ИНЕГ-15.7 сая төгрөг, АТҮТ 16.0 сая төгрөг/

2.8.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,323,413.7 сая, эцсийн үлдэгдэл 6,219,548.9 сая төгрөг болж, 103,864.8 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	5,554,881.4	5,441,846.8	(113,034.6)
Биет бус хөрөнгө	766,840.5	765,074.4	(1,766.1)
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	1,691.8	12,627.7	10,935.9
Дүн	6,323,413.7	6,219,548.9	(103,864.8)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	5,107,203.1	3,640,938.2	(1,466,264.9)
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,216,210.6	2,578,610.7	1,362,400.1)
Дүн	6,323,413.7	6,219,548.9	(103,864.8)

Эх сурвалж:ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 20.7 сая, төрийн өмчийн газруудын худалдан авсан хөрөнгө 29,347.0 сая, балансаас баланст шилжүүлэн авсан 1,501,492.4 сая, үнэ төлбөргүй хандиваар авсан 431.9 сая төгрөгөөр нэмэгдэж, балансаас баланст шилжүүлсэн 1,376,542.9 сая, худалдсан болон акталсан 4,070.8 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд 143,915.5 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь ЗТХЯ-ны барилгын зураг төсвийн 20.0 сая төгрөг, ИНЕГ-ын хөрөнгө оруулалтын шинж чанартай 143,895.5 сая төгрөгийн барилгууд тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагааны хууль, журмыг зөрчиж нийт 285.9 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн /МИАТ ТӨХК 65.0 сая төгрөг, АТҮТ 220.9 сая төгрөг/;
- Жилийн эцсийн тооллого хийгээгүй, эзэнгүйдэх эрсдэлтэй нийт 506.0 сая төгрөгийн хөрөнгө байна. /Булган АЗЗА 471.3 сая төгрөг, Архангай АЗЗА 34.7 сая төгрөг/;
- Холбогдох газрын зөвшөөрөлгүй бэлтгэсэн, данс бүртгэлээс хассан нийт 40.5 сая төгрөгийн хөрөнгө байна. /Чингис хаан ОУНБ-31.3 сая төгрөг, АТҮТ 9.2 сая төгрөг/

2.8.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 447,719.4 сая, эцсийн үлдэгдэл 903,482.3 сая төгрөг болж, 455,762.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
<i>Богино хугацаат өр төлбөр дүн</i>	184,472.8	214,473.9	30,001.1
Богино хугацаат зээлийн өглөг	46,855.0	48,707.0	1,852.0
Өглөг	103,322.2	133,393.0	30,070.8
Урьдчилж орсон орлого	34,295.6	32,373.9	(1,921.7)
<i>Урт хугацаат өр төлбөр дүн</i>	263,246.6	689,008.4	425,761.8
Урт хугацаат үнэт цаас	0.0	357,000.0	357,000.0
Урт хугацаат зээл	263,246.6	332,008.4	68,761.8
Дүн	447,719.4	903,482.3	455,762.9
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	38,723.1	47,443.6	8,720.5
Төсөл, сан	38.1	0.0	(38.1)
ТӨҮГ болон ОНӨҮГ	408,958.2	856,038.7	447,080.5
Дүн	447,719.4	903,482.3	455,762.9

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд дараахь байгууллагуудын өр төлбөр ихэнх хувийг эзэлж байна. Үүнд:

- Монголын төмөр зам ТӨХК-ийн БНХАУ-ын Экспорт-импортын банкны зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн “Төмөр замын хөдлөх бүрэлдхүүний паркийг нэмэгдүүлэх” төслийн зээл, “Бүс нутгийн ложистикийн төвийг хөгжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэх АХБ-ны хөнгөлөлттэй зээл 198,774.4 сая төгрөг, урт хугацаат бондын өглөг 357,000.0 сая төгрөг;
- Автозамын Засвар арчлалтын компаниуд болон Авто импекс ХХК-ийн тоног төхөөрөмжийг шинэчлэх зориулалттай бий болсон дамжуулан зээлийн 10,399.3 сая төгрөгийн үндсэн зээлийн өглөгүүд;
- МИАТ ХК-ийн 2013 онд агаарын хөлөг худалдан авахтай холбоотой Хөгжлийн банк, Голомт, Хас банкууд болон Private Export Funding Corporation, ING Capital LLC банкнуудаас авсан 99,820.5 сая төгрөгийн зээлийн өр, 4,593.9 сая төгрөгийн барьцаат өглөг;
- Зам тээврийн хөгжлийн төвийн ТӨБЗГ-ын 2017 оны 65 дугаар тогтоолоор Арабын эдийн засгийн Кувейтийн сангийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 1,158.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө;
- Автотээврийн үндэсний төвийн 2001 онд Тээврийг хөгжүүлэх төслийн хүрээнд Санхүү, эдийн засгийн яам болон Автотээврийн газар хоорондын NDF-353 дугаар дамжуулан зээлдүүлэх зээлийн 6,351.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Олон жилийн насжилттай өр, төлбөрөө төлж барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 8,464.2 сая төгрөгийн зөрчил байна. /МИАТ ТӨХК 7,575.0 сая төгрөг, Орхон АЗЗА 813.0 сая, Баянчандмань АЗЗА 17.5 сая, Булган АЗЗА 58.7 сая төгрөг/;
- Зөвшөөрөлгүй зээл авсан, санхүүгийн тайланд тусгаагүй 83.3 сая төгрөгийн өр төлбөр байна. /АТУТ 28.0 сая, Налайх АЗЗА 48.0 сая, Орхон АЗЗА 7.3 сая төгрөг/

2.8.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 7,879,778.5 сая, эцсийн үлдэгдэл 7,230,576.2 сая төгрөг болж, 649,202.3 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №8 Нийт засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /ЗГ-ын сан, ОН-ын сан/	528,135.7	2,251,088.7	1,722,953.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	282,893.9	40,224.3	(242,669.6)
Өмч /хувийн/ /ТӨҮГ/	0.0	113.4	113.4
Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/	380.6	532.9	152.3
Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	2,471.6	2,603.3	131.7
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	1,044,330.0	850,051.1	(194,278.9)
Хуримтлагдсан үр дүн	3,767,985.2	1,830,473.1	(1,937,512.1)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,253,581.5	2,255,489.4	1,907.9
Дүн	7,879,778.5	7,230,576.2	(649,202.3)
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	6,236,809.4	4,221,881.3	(2,014,928.1)
Төсөл, сан	1,248.2	1,579.8	331.6
ТӨҮГ болон ОНӨҮГ	1,641,720.9	3,007,115.1	1,365,394.2
Дүн	7,879,778.5	7,230,576.2	(649,202.3)

Эх сурвалж: ЗТХС-ын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд Засгийн газрын оруулсан капитал данс ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын үндсэн хөрөнгийн нэмэгдлээр 1,260,138.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал:

ИНЕГ тайлант хугацаанд ТӨБЗГ-ын 2019 оны 382 дугаар тогтоолоор “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-өөс балансаас балансад шилжүүлэн авсан шинэ нисэх буудлын үйл ажиллагаанд ашиглагдах барилга, байгууламж, машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, дуусаагүй барилга, байгууламж, биет бус хөрөнгө нийт 1,255,321.1 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оруулсан капитал данс ЗТХС-ын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарласан ногдол ашгийн 7,860.6 сая төгрөгөөр, тайлант үеийн үр дүнгийн 134,092.1 сая төгрөгийн сөрөг үзүүлэлттэй гарч тус тус хорогдсон байна.

Аудитын илрүүлэлт:

- Улсын бүртгэлийн гэрчилгээний дүн санхүүгийн тайлангаас зөрүүтэй илэрхийлэгдсэн, алдагдалтай ажилласан нийт 423.3 сая төгрөгийн зөрчил байна. /Эрдэнэсант АЗЗА 60.2 сая төгрөг, Баянчандмань АЗЗА 284.4 сая, Архангай АЗЗА 78.7 сая төгрөг/

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Зам, тээвэр хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант онд 156,210.0 сая төгрөгийн орлого улсын төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр төлөвлөгөөг 100.0 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт №9 Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ИНЕГ /навигацийн төлбөр/	156,000.0	156,000.0	0.0	100.0
Хөлөг онгоцонд МУ-ын төрийн далбаа мандуулсны орлого /Далайн захиргаа/	210.0	210.0	0.0	100.0
Нийт дүн	156,210.0	156,210.0	0.0	100.0

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх зам, тээврийн бодлого, удирдлага хөтөлбөрт зориулан 251,298.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 9,517.0 сая төгрөгийг урсгал зардалд, 241,781.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 249,149.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 2,150.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 233,460.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдож, 15,688.8 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосон байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 6,000.3 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 3,850.3 сая төгрөгөөр давсан нь улсын чанартай авто замын төлбөр хураах цэгүүд нэмэгдэж, орлого нь өссөнтэй холбоотой байна.

Төсвийн нийт зардал 235,572.5 сая төгрөг буюу 15,726.5 сая төгрөгөөр дутуу зарцуулж, 93.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хөрөнгө оруулалтын 141 төсөл, арга хэмжээнд 241,781.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 226,093.1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Ажил гүйцэтгэгч байгууллагад гүйцэтгэлээр 185,967.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 8,716.7 сая төгрөгийн суутган барьцаа дансанд, 3,749.1 сая төгрөгийг захиалагчийн хяналтын дансанд, норм, нормативын зардалд 668.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Он дамжин хийгдэхээр болсон ажлын 26,990.9 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Тайлант онд төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 9,050.0 сая төгрөгийн автозамын ажлын тендер шалгаруулалт удаашралтай байдлаас шалтгаалан хийгдээгүй, ЗГ-ын 2019 оны 430 дугаар тогтоолоор 26,990.9 сая төгрөгийн дуусаагүй хөрөнгө оруулалтыг он дамжин хийгдэхээр болсон.

Хийгдээгүй ажлын 26,990.9 сая төгрөгийн санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсвийн захирагчаас 2,866.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнд: Засгийн газрын 2019 оны 236 дугаар тогтоолоор 1,395.4 сая, Сангийн сайдын 2019 оны 251 дүгээр тушаалаар 1,470.7 сая нийт 2,866.1 сая төгрөг олгосноос 2,852.8 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 13.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Улсын төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 33.0 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн зарцуулалтаас хэмнэгдсэн 13.3 сая төгрөг, Улсын комисс хүлээн авсан 1,425.9 сая төгрөгийн автозамын барилгын ажлын техник хяналтын зардлыг, Авто тээврийн үндэсний төвөөс тээврийн хэрэгслийн гэрчилгээг борлуулсны орлого болох 178.9 сая төгрөг, нийт 1,651.1 сая төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 49 төрийн /орон нутгийн/ өмчит аж ахуйн нэгж, 1 тусгай сан, 1 төслийн нэгжийн нийт 56 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 53 байгууллага аудитад хамрагдсан, 2 итгэл үзүүлсэн, 1 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 9 байгууллагыг түүвэрт хамруулж, 44 байгууллагад дүгнэлт хүргүүллээ. Үүнд: “Зөрчилгүй” 35, “Хязгаарлалттай” 9 /Иргэний нисэхийн ерөнхий газар, Чингис хаан Олон улсын нисэх буудал, Нисэх буудлуудын удирдах газар, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, Монголын төмөр зам ТӨХК, Орхон АЗЗА ТӨХК, Налайх АЗЗА ТӨХК, Баянчандмань АЗЗА ТӨХК, Архангай АЗЗА ТӨХК/, дүгнэлт өгсөн байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 109,705.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 82,119.5 сая төгрөгийн алдааг залруулж, 111.2 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 6,776.8 сая төгрөгийн зөрчилд 39 албан шаардлага, 20,697.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 162 зөвлөмж өглөө.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд 51.9 сая төгрөгийн авлагыг илүү дутуу, 51.9 сая төгрөгийн урьдчилгааг илүү, 244,095.2 сая төгрөгийн биет хөрөнгийг илүү, 244,095.2 сая төгрөгийн биет бус хөрөнгийг дутуу, 12,909.4 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүн дансыг дутуу нэгтгэсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд 4,453.7 сая төгрөгийн санхүүжилтийн орлого илүү, 460.5 сая төгрөгийн зардлыг илүү нэгтгэсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлтийн тайланд 12,909.4 сая төгрөгийн хуримтлагдсан үр дүнг дутуу нэгтгэсэн;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд 16,785.7 сая төгрөгөөр үйл ажиллагааны орлогыг илүү нэгтгэсэн;
- Төсвийн ерөнхийлөн захирагч болон харьяа байгууллага хооронд үүссэн 16,785.7 сая төгрөгийн давхардсан орлого болон зардлын ажил гүйлгээний устгах бичилтийг дутуу хийж тайлагнасныг санхүүгийн тайланд залрууллаа.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 13,901.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 12,909.4 сая төгрөгийн алдааг залруулж, 991.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар

Аудитаар нийт 4,305.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,157.4 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 148.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төсвийн 6 байгууллагаас 3 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Зөрчилгүй 2, Хязгаарлалттай 1 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 4,565.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 4,282.5 сая төгрөгийн алдааг залруулж, 283.2 сая төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өглөө.

Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа төрийн болон орон нутгийн өмчит 48 аж ахуйн нэгж байгууллагаас 2 байгууллагад итгэл үзүүлж, 5 санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, 1 байгууллага аудитад хамрагдаагүй /Авто импекс ХК/, “Зөрчилгүй” 32, “Хязгаарлалттай” 8 дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 86,927.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 64,927.2 сая төгрөгийн алдааг залруулж, 111.2 сая төгрөгийн зөрчилд 21 төлбөрийн акт тогтоож, 2,619.4 сая төгрөгийн зөрчилд 37 албан шаардлага, 19,269.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд 145 зөвлөмж өглөө.

Тусгай санд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар

Авто замын сангийн 2019 оны санхүүгийн тайланд аудит хийж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 5.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.4 сая төгрөгийн алдааг залруулж, 5.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өглөө.

Төсөл, хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитаар

Харьяа 1 төсөл хөтөлбөрийн нэгжийн санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулав.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарим Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагыг ТӨБЗГ томилдог, ажлын гүйцэтгэлийг хянадгаас шалтгаалан ЗТХЯ-ны Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтсээс бусад харьяа байгууллагад тавих хяналтыг бууруулж, хариуцлагыг сулруулж байгаа нь анхаарал татахуйц асуудал байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Зам, тээврийн хөгжлийн яам нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 9009 мэдээллийг хугацаанд нь, 469 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, тендерийн ерөнхий мэдээлэл гэх мэт мэдээллүүдийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид өгсөн 4.2 сая төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоосноос бүрэн барагдуулсан, 5,249.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 19 албан шаардлага хүргүүлснээс 1,774.4 сая төгрөгийн 16 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 84 зөвлөмж өгснөөс 71 зөвлөмжийг хэрэгжүүлж, 13 зөвлөмж хэрэгжих шатандаа буюу зөвлөмжийн хэрэгжилт 85.1 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хязгаарлалттай дүгнэлт

Залруулагдаагүй 27,585.8 сая төгрөгийн алдаа, зөрчил нь бидний тогтоосон 13,503.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлтийг өгч байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох

хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Зам, тээврийн хөгжлийн сайдын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа зарим байгууллагуудын санхүүгийн тайланд тусгасан 367.7 сая төгрөгийн олон жил болсон хуримтлагдсан авлага /3 жилээс дээш/-ууд байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Харилцагч байгууллагаас авах авлагыг тухай бүр баталгаажуулж, барагдуулаагүйгээс авлага найдваргүй болох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа байгууллагуудын олон жил болсон авлагуудыг барагдуулах, хяналт тавьж ажиллах талаар нэгдсэн арга хэмжээ авч, зохион байгуулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт 286.1 сая төгрөгийн авлага, 66.0 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг баримтлан ажиллаагүйтэй холбоотой байна.

3.2.2 Эрсдэл:

Харилцагч байгууллагатай тооцоог нийлж баталгаажуулаагүйгээс найдваргүй авлагыг бий болгох.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн үлдэгдлийн тооцоо нийлж баталгаажуулж байх, авлага, өглөгийн үлдэгдэлд дээд шатны захирагч хяналт тавих.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.3 Хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд тусгасан 272.0 сая төгрөгийн авлага нь ЗТАЖЯ /хуучнаар/-ны 2006-2007 онд үүссэн тодорхой бус, ямар шалтгаанаар үүссэнийг тодорхойлох боломжгүй авлагууд байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Харилцагч байгууллагаас авах авлагыг тухай бүр баталгаажуулж, барагдуулаагүйгээс авлага найдваргүй болох.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хөрөнгө оруулалтын тайланд бүртгэлтэй тодорхойгүй авлагыг шийдвэрлэх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Дотоод аудит, дотоод хяналтын талаар

3.4.1 Илрүүлэлт:

